

**“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

д/д	Арга хэмжээ, зорилт	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.							
1.1	Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн замын тээврийн ажлыг оновчтой, аюулгүй зохион байгуулах	-	Ачаа тээвэр сая.тн	2022 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 0.12 сая.тонн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.12 сая.тонн буюу нийт 0.24 сая.тонн ачааг тээвэрлэсэн.	Жилийн эцсийн байдлаар: IV улирал: Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 5.0 сая.тн ачаа тээвэрлэнэ.	2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар 2023 онд өссөн дүнгээр нийт 1,924,129.64 тонн ачаа тээвэрлэж төлөвлөгөөний биелэлт 38.48 хувийн биелэлттэй байна. Тээвэрлэлтийн чиглэлээр нь авч үзвэл Тавантолгой-Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд 624,008.05 тонн ачаа тээвэрлэж 20,38 хувь, Тавантолгой-Цогтцэций-Тавантолгой чиглэлд 1,300,121.58 тонн ачаа тээвэрлэж, тус чиглэлийн төлөвлөгөөний биелэлт 67.07 хувь байна. Тээвэрлэсэн ачааны төрлөөр нь авч үзвэл: Чингэлтэй экспортын нүүрс боомтоор: • Гашуунсухайт боомтоор -567,088 тонн • Бусад (МТЛ) боомтоор -741,842 тонн Дотоодын эрчим хүчний нүүрс тээвэр /мидлинг/: • Тавантолгой түлш ХХК-428,119 тонн • Цемент шохой ТӨХК-18,450 тонн Нефтийн бүтээгдэхүүн: Шунхлай ХХК- 49,525 тонн.	30%
1.2	Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авах, гэрчилгээжүүлэх.	18.29 тэрбум төгрөг, 4.6 сая.ам доллар	Хөдлөх бүрэлдэхүүний тоо	Зүтгүүр: Зүтгүүрийн худалдан авалт, зураг төсөл, техникийн үзүүлэлттэй холбоотой баримтуудыг бэлэн болгосон. Вагон: 2022 онд 100 хагас вагон, 350 тавцант вагоныг хүлээн авч, явц 55 хувьтай.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Нийт 16 ширхэг зүтгүүр, 360 ширхэг вагоныг хүлээн авч гэрчилгээжүүлнэ. SD70Ase серийн 2 илчит тэрэг нийлүүлэгдэх туршилтын аялал эхэлсэн байх.	Ерөнхий гүйцэтгэгч “Бодь интернэшнл” ХХК-тай байгуулсан ЕРС гэрээний хүрээнд нийлүүлэгдэх 16 зүтгүүрийг 2023 оны 11 дүгээр сарын 02-ны BI-TTGS-LTR-4994-00 тоот албан бичгээр эхний ээлжийн 2 зүтгүүр 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр нийлүүлэгдэж, дараагийн ээлжийн 14 зүтгүүрийг 2024 онд багтаан үе шаттайгаар нийлүүлэх тухай албан тоотыг ирүүлсэн. SD-70Ase/LW загварын зүтгүүрийн эхний 2 нэгж зүтгүүрийн нийлүүлэлтийн явц, зүтгүүр үйлдвэрлэлчийн зүгээс ирүүлсэн сургалтын хөтөлбөрийн хамт “Бодь Интернэшнл” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн BI-TTGS-LTR-5097-00 дугаартай албан бичгээр ирүүлсэн. ЕРС гэрээний Багц-5 [Хөдлөх бүрэлдэхүүн]-д заасан нийт 812 ширхэг ачааны вагоныг хүлээн авч, одоогийн байдлаар хагас вагон 400, тавцант вагон 390, хашлагатай тавцант вагон 13, битүү вагон 8, GCU-300K загварын 1ш өөрөө явагч зорчигчийн хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээн авсан. Хүлээн авалтын нийт гүйцэтгэл явц 100%-тай байна. Түүнчлэн 811 вагоны хувийн дугаар болон Төмөр замын тээврийн аюулгүй байдлаар холбоотой 812 вагоны объектын гэрчилгээг ГТХЗНТ-с авсан.	50%

1.3	Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмжийг хүлээн авч гэрчилгээжүүлэх.	ЕРС гэрээ	Хүлээн авах төхөөрөмжийн тоо	Зүтгүүр: -12 суурин тоног төхөөрөмж, 34 багаж тоног төхөөрөмж төслийн талбайд буусан. Хүлээн авсан байдал 0 хувьтай. Вагон: 12 төрлийн 1340 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүлээн авсан буюу нийт хүлээн авах тоног төхөөрөмжийн 14 хувьтай хүлээж авсан.	Жилийн эцсийн байдлаар: IV улирал: Зүтгүүр: Суурин 12 тоног төхөөрөмж, 140 багаж тоног төхөөрөмжүүдийг 2023 оны III улирлаас Депо ашиглалтад орох үед гэрчилгээний хамтаар 100 хувь хүлээн авна. Вагон: Нийт хүлээн авах тоног төхөөрөмжийн үлдэгдэл 86 хувийг хүлээн авна. Хөдлөх бүрэлдэхүүн засварын төвд хос дугуйн парк байгуулсан байна.	ЕРС гэрээний Багц-6 (Хөдлөх бүрэлдэхүүний засварын тоног төхөөрөмж)-д заасан Зүтгүүрийн 152ш, Вагоны 285ш тоног төхөөрөмжүүдийн хүлээн авалтын явц дараах байдалтай байна. Үүнд: - Зүтгүүрийн депод 56 тоног төхөөрөмж; - Вагон депод 104 ш тоног төхөөрөмж, 1340 ш гар багаж хэмжих хэрэгсэл хүлээн авахаас 404 ширхэг хэмжих хэрэгсэл, 936 ширхэг гар багаж хүлээн авсан. Гашуунсухайт засварын газарт 20 тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авсан. Вагон депогийн тоног төхөөрөмж суурилуулалтын явц 90% хувьтай байна. Зүтгүүр депогийн тоног төхөөрөмжийн суурилуулалтын явц 70%-тай байна.	90%
1.4	Тээврийн зохион байгуулалтад орчин үеийн дэвшилтэт техник, технологи, менежментийн аргуудыг хэрэглэх.	ЕРС гэрээ	Гүйцэтгэлийн хувь	Хяналтын 5Т системийн гүйцэтгэлийн ажил 20 хувьтай.	Жилийн эцсийн байдлаар: IV улирал: Хяналтын 5Т системийн гүйцэтгэлийн ажил 100 хувь дуусна.	Галт тэрэгний автомат зурмагийн (ГИД) программын сургалт 3 удаа, цахим уулзалтыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 45 ажилтан хамрагдсан. Галт тэрэгний автомат зурмагийн программын дагуу галт тэрэг хүлээн авч явуулан ашиглаж байна. Хяналтын 5Т системийн ажил Багц-3 дохиолол төвлөрүүлэлт хориглол, холбооны шилэн кабелийн ажил Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 100 хувь бүрэн дууссан. Нэмэлтээр 2 газар суурилуулалтын ажил хийгдэж байна. Дохиолол холбооны нийт ажил 100 хувьтай, холбогдох сургалтыг 5 удаа явуулсан.	100%
1.5	Тээвэр тээврийн логикийн үйлчилгээний болон бүс нутгийн уул уурхайн компаниудтай	-	Шийдвэр гаргуулж ажил эхлүүлсэн эсэх	Тээвэр зуучийн гэрчилгээ авах материалуудыг бүрдүүлсэн.	Хагас жилийн байдлаар: I улирал: Шийдвэр гаргуулна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Тээвэр зууч логикийн үйлчилгээг эхлүүлнэ.	Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 23/А54/05 дугаартай "Төмөр замын тээвэр зуучлалын зөвшөөрлийн гэрчилгээ"-г 3 жилийн хугацаатай авсан. Тавантолгой-Цогтцэций болон Тавантолгой-Цогтцэций-Эрзэн чиглэлд тээвэрлэлтийг нэмэгдүүлэх боломж чиглэлээр танилцуулга бэлтгэж, Зам, тээврийн хөгжлийн яаманд 1/713 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЗТХЯ-аас Тавантолгой-	100%

	хамтын ажиллагааг өргөжүүлэх.				Цогтцэций-Зүүнбаян-Эрээн чиглэлд тээвэрлэхээр төлөвлөж буй 200 мян.тн ачаа нь Суурь бүтцүүдийн хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөний протоколд заасан хэмжээнээс илүү байх тул улсын комисс ажилласны дараа "Суурь бүтэц хооронд ачаа солилцох, дамжин өнгөрөх тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам"-ын хүрээнд дахин тохиролцсоны үндсэн дээр талууд гэрээг байгуулах шаардлага үүсэх тухай хариу ирүүлсэн. Иймд Тавантолгой-Цогтцэций-Зүүнбаян-Эрээн чиглэлд тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж эхлээгүй байна. Тавантолгой-Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг улсын комисст хүлээлгэн өгсний дагуу дараах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тавантолгой-Гашуунсухайт-Ганцмод болон Тавантолгой-Цогтцэций-Зүүнбаян-Эрээн чиглэлийн тээвэр зуучлалын үнэ, тарифын судалгаа хийгдсэн. Тавантолгой-Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн тээвэрлэлтэй холбоотой авто тээврийн компаниудтай хамтран ажиллах уулзалт зохион байгуулан тээвэр зуучлалын шинэ үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна. "Тавантолгой төмөр зам" ХХК, "Цемент шохой" ТӨХК хооронд 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Тэг-2023/21 дугаартай тээвэр зуучлалын гэрээ байгуулан Тавантолгой-Хөтөл-Тавантолгой чиглэлд тээвэр логистикийн үйлчилгээг үзүүлж байна. Цаашид Дархан-Эрээн-Дархан, Тавантолгой-Өргөн-Тавантолгой чиглэлд тус тус тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Гашуунсухайт шилжүүлэн ачих терминалын бүтээн байгуулалтын ажил 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 98.33 хувийн гүйцэтгэлтэй байна. Шилжүүлэн ачих терминалыг гаалийн хяналтын бүсээр зарлуулах тухай албан хүсэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/1730 дугаартай албан бичгээр, тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг нэгдсэн системээр тус тус Гаалийн ерөнхий газарт хүргүүлсэн. Шилжүүлэн ачих терминалын гарцын асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг хүсэх тухай хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 1/163 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн асуудлаар Ерөнхий сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтын төмөр зам, шилжүүлэн ачих байгууламжийг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэгт танилцуулга бэлтгэж, энэ оны 03 дугаар сарын 17-ны өдөр 1/413 тоот албан бичгээр хүргүүлсэн. Гашуунсухайт
1.6	Гашуунсухайт Шилжүүлэн ачих терминалыг гаалийн хяналтын бүсээр зарлуулах, Шилжүүлэн ачих терминалаас экспортод гарахтай холбоотой гарц болон квотын асуудлыг шийдвэрлүүлэх.	-	Төслийн ажлын гүйцэтгэл, хувь	ШАТ төслийн гүйцэтгэлийн явц 23.3 хувьтай хувьтай байна.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Гашуунсухайт ачих Шилжүүлэн терминалыг Гаалийн хяналтын бүсээр зарлуулж, төслийн ажил 100 хувь дуусна.	100%

					Шилжүүлэн ачих терминалд ирсэн чингэлэгтэй экспортын нүүрсийг захиалгат дуудлага үйлчилгээ дуудан, Гашуунсухайт авто замаар экспортод гаргах ажлыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай хамтран зохион байгуулж байна. Боомтын сайдтай 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр уулзалт зохион байгуулж, хилийн гарц, квотын талаар танилцуулга хийж, тус чиглэлээр хийсэн судалгааг хүргүүлсэн. Мөн Боомтын сайдын зүгээс дэмжиж ажиллахаа илэрхийлсэн. Мөн 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулгад 1/986 тоот албан бичгээр “Экспортын квот болон гарцын асуудлыг шийдвэрлэж өгөх тухай” хүсэлтийг хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/4113 тоот хамтран ажиллах тухай албан хүсэлтийг Монгол улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга Б.Тулга, Хилийн боомтын захиргаа, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтрүүлэх тусгай гарц гаргах ажлыг шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан.
Зорилт 2. Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ.					
2.1	“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын суурь бүтэц, барилга угсралт, үйлдвэрлэлийн ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах.	1.55 их наяд төгрөг, 391.1 сая.ам.доллар	Ашиглалтад оруулсан эсэх	Төслийн гүйцэтгэл-86 хувьтай.	2023 оны 11 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар төслийн нийт гүйцэтгэл 92.4 хувьтай, төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 96.9 хувьтай байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын цогцолбор төслийн хүрээнд талуудын хооронд байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу хийгдэх ажлууд бүрэн хийгдэж, Эрчим хүч хангамжийн ажлыг хүлээн авах Улсын комисс эрчим хүчний сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/85 тоот тушаалаар байгуулагдан 2023 оны 04 сарын 05-ны өдөр, Төмөр замын дээд, доод бүтэц, Дохиолол холбооны ажлыг хүлээн авах Улсын комисс Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар тушаалаар байгуулагдан 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр тус тус ажиллаж, төмөр замыг байнгын ашиглалтад хүлээн авсан. Төслийн нийт гүйцэтгэл 100 хувьд хүрээгүй байгаа нь зүтгүүрийн нийлүүлэлттэй холбоотой бөгөөд цар тахлын нөлөө зэрэг бусад шалтгаант хүчин зүйлүүдээс үүссэн. Зүтгүүрийн нийлүүлэлт 2024 оны II улиралд зүтгүүр бүрэн нийлүүлэгдэж дуусахаар ажиллаж буй тухай “Бодь Интернэшнл” ХХК-иас 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн BI-TTGS-LTR-4994-00 дугаартай албан бичгээр мэдэгдсэн.

100%

2.2	"Тавантолгой-Гашуунсухайт" болон Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр зам"-ын суурь бүтцийг ашиглалтад оруулах.	80 сая төгрөг	Ашиглалтад оруулсан эсэх	Төслийн 6 багц ажлын гүйцэтгэл-79.22 хувьтай хэрэгжсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Бэлтгэл ажлыг хангаж, улсын комисс ажиглуулж, 100 хувь ашиглалтад оруулсан байна.	2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар төслийн нийт гүйцэтгэл 95.38%, төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99% байна. Замын дээд, доод бүтцийн гүйцэтгэл 100%-тай байна. 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр А/239 тоот тушаалаар Техникийн комиссын дүгнэлт гарсан. Авто замын өөрчлөлтийн ажил 100% бүрэн дууссан. Шилэн кабелийн ажил 100% бүрэн дууссан. Дохиолол холбооны нийт ажил 93.4% болж өссөн. Цахилгаан эрчим хүчний ажил 100%-тай байна. Хөдлөх бүрэлдэхүүнийг худалдан авалт, нийлүүлэлтийн гүйцэтгэл 84.7%-тай буюу Зам хэмжигч, сэв шалгагч, мотовоз 3 төслийн талбайд ирсэн 100%, Сэлгээний зүтгүүр үйлдвэрлэлийн явцад, гүйцэтгэл 45%-тай байна. Төслийн гүйцэтгэл 100%-д хүрээгүй шалтгаан нь сэлгээний зүтгүүрийн үйлдвэрлэгч "NRE" LLC 2023 оны 05 дугаар сард татан буугдаж "TRM NRE" компани эд хөрөнгө, эрхийг шилжүүлэн авсан бөгөөд Ерөнхий гүйцэтгэгч шилжсэн зүтгүүрийн эд ангиудаар сэлгээний зүтгүүр үйлдвэрлэхээр захиалга өгөн, 2023 оны 08 дугаар сард гэрээ байгуулан сэлгээний зүтгүүрийг үйлдвэрлэлийн явц дахин явагдсан. 2023 оны 10 дугаар сард ерөнхий гүйцэтгэгч үйлдвэр дээр очиж явцтай танилцахад шаардлагатай худалдан авалтуудын захиалгууд бүрэн хийгдсэн бөгөөд угсралтын ажил эхэлмэгц сэлбэг хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжүүд болон эд ангиудын нийлүүлэлтийг хийж эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэрлэгчийн зүгээс төлөвлөсөн хугацаанаас 3 сарын өмнө буюу 2024 оны 09 дүгээр сард нийлүүлэлт хийхээр зорилго тавин ажиллаж байгаагаа мэдэгдсэн.	90%
2.3	"Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв" төслийн барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт тавьж, ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах.	143.42 тэрбум төгрөг	Ашиглалтад оруулсан эсэх	Төслийн гүйцэтгэл - 55.81 хувьтай. Төслийн мастер төлөвлөгөө боловсруулагдсан.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх, хяналт тавина. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Бэлтгэл ажлыг хангаж, улсын комисс ажиглуулж, 100 хувь ашиглалтад оруулсан байна.	Төслийн нийт гүйцэтгэл 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 83.84% байна. Төслийн батлагдсан Ажил гүйцэтгэх МАСТЕР төлөвлөгөөний дагуу 6 багц ажлыг нийт 31 сарын хугацаанд барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусгааар Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Ковид-19 цар тахлын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнөөс БНХАУ-с нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, тээвэрлэлт доголдсонтой холбоотойгоор төслийн дуусгах хугацааг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасан.	90%
2.4	Гашуунсухайт-Ганцмод боомтын 7.9 км төмөр замын	-	ТЭЗҮ боловсруул ах	Хил дамнансан төмөр замын	Хагас жилийн байдлаар:	Төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд:	70%

ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх.		Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.	II улирал: ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг 100 хувьд хүргэнэ. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулна. Барилгын ажлыг 30 хувьд хүргэнэ.	-Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх Зам, тээврийн хөгжлийн яамны Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөл болон зөвлөлөөр 2023 оны 08 дугаар сарын 18, 21-ний өдрүүдэд тус тус хэлэлцүүлж нийт 77 зөвлөмж авч засан, сайжруулсан. Ийнхүү 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөлөөр орж дэмжигдсэн. -Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 08/5425 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамаар батлагдан ирүүлсэн. Үүний хүрээнд хээрийн хэмжилт, судалгааны ажлыг гүйцэтгэж байна. -Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 136 дугаар захирамжаар байгуулагдсан Төмөр замын холболтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсэг БНХАУ-ын талтай 2023 оны 09 дүгээр сарын 08, 15-ны өдрүүдэд цахимаар, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод тус тус хуралдсан. -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 104 дүгээр тушаалаар "Төмөр замын холболтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх" ажлын дэд хэсэг шинэчлэгдэн байгуулагдсан. -Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн "Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 310 дугаартай тогтоолын 6 дахь хэсэгт зааснаар Төмөр замын зурвас газрын Улсын тусгай хэрэгцээний газартай давхацсан хэсэгт газар ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэхийг даалгасны дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын 208.5 км-ээс улсын хил хүртэлх чигийн дагуух зурвас газар ашиглуулах гурвалсан гэрээг байгуулж, тогтоолын хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллах тухай хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайд 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр 01/4302 дугаартай албан бичгээр Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн. Мөн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн газар ашиглах зөвшөөрлийг авах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тогтоолын төсөл, танилцуулга, хурлын тэмдэглэлийг шинэчлэн боловсруулж 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. -Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, иж бүрэн зураг төсөл
---	--	--------------------------------	--	---	---

						боловсруулах ажлын инженерийн нарийвчилсан зураг төслийн ажлын хэзэрийн хэмжилт, суурь судалгааны ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан чигийг баталгаажуулах, газар ашиглах эрхийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн холбогдох байгууллагаар шугамын чигийг батлуулах ажлыг зохион байгуулах тухай хүсэлтийг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 1/1892 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. -Монгол Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/319 дүгээр тушаалаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих, үүнтэй холбоотойгоор хилийн түр гарц нээх, журам тогтоох асуудлаар Монголын Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг БНХАУ-ын талтай хэлэлцэн тохиролцох ажлын хэсэг байгуулагдсантай холбоотойгоор БНХАУ-ын талтай 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. Цахим уулзалтаар талууд тохиролцсоны дагуу Хятадын талаас хэлэлцээрийн анхны төслийг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн. Төслийн гүйцэтгэл: Төмөр замын чиг тогтоох 90%; Суурь судалгааны урьдчилсан ажил 100%; БОНБУ, Археологи, Палеонтологи, Түүх угсаатны ажил 50%; Хэзэрийн судалгааны ажил 55%; Иж бүрэн зураг төсөл боловсруулах ажил 5%-тай тус тус хийгдэж байна.	
2.5	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын Гашуунсухайт боомт дахь шилжүүлэн ачих терминал байгуулах	92 тэрбум төгрөг, 23,158,584.72 ам. доллар	Төслийн ажлын гүйцэтгэл, хувь	Төслийн ажлын гүйцэтгэл 35 хувь	Хагас жилийн байдлаар: II улирал: Төслийн гүйцэтгэл 100 хувь хүргэнэ.	2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар төслийн нийт гүйцэтгэл 98.33%, төслийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 99% байна. Чингэлэг талбайн суурийн дүүргэлт тэгшилгээний ажил дуусаж 1-4 дүгээр замын харалдаа бетон суурийн умалын ажил дууссан. Багц ажлын гүйцэтгэл 99.44%-тай байна. ЗТХ-ийн Сайдын 2023 оны А/333 тушаалын дагуу Техникийн комисс ажилласан. Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хийгдэж байна. Төмөр замын дээд, доод бүтцийн ажил 100%-тай байна. Барилга байгууламжийн багц ажлын гүйцэтгэл 96.24%-тай, Дохиолол холбооны ажил 94.64%-тай байна. Машин механизм, тоног төхөөрөмж 100%, Гражын тоног төхөөрөмж 88.47%, Гаалийн хяналтын камер сервер дагалдах тоног төхөөрөмж 63%-тай байна. Багц ажлын гүйцэтгэл 92.66%-тай тус тус байна.	100%

Зорилт 3. Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.						
3.1	Замын дээд бүтцийн материалын нөөцийг бүрдүүлэх.	Нөөц бүрдүүлэлт бүрэн хийгдсэн эсэх	Зайлшгүй шаардагдах нөөц материалын судалгаа хийгдсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Материалын нөөц бүрдүүлэлтийн судалгаа хийгдэж, шийдвэр гарсан байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Шаардлагатай материалын нөөц бүрдүүлэлт, замын дээд бүтцийн материалын нөөцийг төлөвлөсөн хэмжээнд бүрэн бүрдүүлж нөөцөлсөн байна.	Замын дээд доод бүтцийн нөөцийг бүрдүүлэх 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 39 төсөл арга хэмжээнээс 15 төрлийн 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалтын гүйцэтгэл, 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авалтаас 736 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалтыг төсөвт өртгийг бууруулсан дүнгээр худалдан авалтыг гүйцэтгэсэн.	100%
3.2	Суурь бүтцийн байгууламжуудын найдвартай, бүрэн бүтэн байдлыг хангах.	Журам боловсруулсан эсэх, төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	Суурь бүтэц шалгах төлөвлөгөө график гаргасан.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Холбогдох журам батлагдсан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу суурь бүтцийг шалгах ажлыг тогтмолжуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Шаардлагатай тохиолдолд тухай бүр ажлын хэсэг зохион байгуулна. Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.	Батлагдсан төлөвлөгөө, графкийн дагуу замын дээд бүтцэд сав шалгах тэргэнцэр 866.75км замд, зам хэмжигч вагон, сав шалгах тэргэнцрээр 2507.2 км-т, явганаар 3366.71 км замд үзлэг шалгалтыг хийсэн 100 хувь, Хориг хашаанд нийт 101187.8 км-т үзлэг хийж биелэлт 100 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна. Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс давхардсан тоогоор хоорондын замд 107527.5 пог/м элс цэвэрлэх ажил хийсэн. Дохиолол холбоо, цахилгаан хангамжийн байгууламжид IV улирлын эхний хагасын байдлаар 2534 удаагийн үзлэг шалгалт хийхээс 2534 удаа өдөр тутмын үзлэг, шалгалтыг хийгээд байна.	100%
3.3	Дохиолол, холбоо, эрчим хүчний байгууламжийн нөөц аваарын сэлбэгийн бүрдүүлэлт хийх.	Нөөц бүрдүүлэлт бүрэн хийгдсэн эсэх	Зайлшгүй шаардагдах сэлбэгийн судалгаа хийгдсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Шаардлагатай материалын нөөц бүрдүүлэлт хангагдсанаар гэмтэл саатлын үед яаралтай түргэн шуурхай засварлаж ажилласан байна.	Дохиолол, холбоо, эрчим хүчний байгууламжийн аваарын нөөц сэлбэгийн бүрдүүлэлтийг хийх ажлын хүрээнд ерөнхий гүйцэтгэгч "Бодь интернэшнл" ХХК-иас дохиолол холбоо, төвлөрүүлэлт хоригтолын байгууламжийн сэлбэг хэрэгсэл 98, эрчим хүчний системийн засвар үйлчилгээний 38, нийт 136 нэр төрлийн нөөц сэлбэгийг хүлээн авснаар 2023 оны сэлбэгийн нөөц бүрдүүлэлтийн ажил дууссан.	100%
3.4	Суурь ашиглах, эзэмшихтэй холбоотой тусгай зөвшөөрлүүд авах.	Ажлын гүйцэтгэл, хувь	Техникийн комисс 11 удаа ажиллаж, үүнээс 3 комиссын	Хагас жилийн байдлаар: I улирал: Тусгай зөвшөөрөл авах ажлыг 100 хувь дуусгана.	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын эрчим хүчний байгууламжид улсын комисс ажилласан дүгнэлтэд тусгай зөвшөөрөл авах хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллагатай гэрээ хийх үүрэг өгсний дагуу "ЦДҮС" ТӨХК-ийн Говийн бүсийн салбартай 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдөр АГТ/-2023/20 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна.	90%

				Дүгнэлт хүлээгдэж байна.	Эрчим хүчний зохицуулах хороонд 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 1/1473 тоот албан бичгээр шалгуулах материалыг хүргүүлсэн. Одоогийн байдлаар дараах тусгай зөвшөөрлүүдийг аваад байна. Үүнд: Төмөр замын суурь бүтэц ашиглах, засварлах, суурь бүтэц барих, дээд бүтэц угсрах, ТЗ автоматик телемеханик угсрах зэрэг 10 төрлийн тусгай зөвшөөрөл аваад байна. Мөн зам засвар, арчлалт, оношилгоо, хэмжилт хийх бүх төрлийн машин, механизмын гэрчилгээг авсан.
Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.					
4.1	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалын дагуу нийт ажилтны, эрсдэлтэй ажлын байрны, ХАБЭА хариуцсан ажилтны сургалтыг зохион байгуулах.	Ажлын явц, хувь	-	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын тушаал болон бусад тушаал шийдвэрийг мөрдөж ажилласан.	“Даралтад савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн сургалт”-ыг “Цог зориг” ХХК-ийн сургалтын байгууллагатай хамтран Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлах Тавантолгой өртөө-Гашуунсухайт өртөөний ажлын байранд очиж зохион байгуулсан. Сургалтад нийт инженер техникийн 20 ажилтан хамрагдаж гэрчилгээг хүлээн авсан. “Өндөрт ажиллах аюулгүй ажиллагааны сургалт”-ыг “МКП” ХХК-ийн сургалтын байгууллагатай хамтран “Тавантолгой өртөө”-ний ажлын байранд олол, дадлагыг хослуулан 35 ажилтанд зохион байгуулсан. “Краны бүрэн бүтэн байдал хариуцагчийн сургалт”, “Ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч”-ын сургалт, “Осорлогч дохионы сургалт”, “Чингэлэг өргөгчийн операторын сургалт”-уудыг “МКП” ХХК-ийн сургалтын албатай хамтран зохион байгуулж, нийт 72 ажилтан хамрагдан, гэрчилгээ авсан. Өндөр эрсдэлтэй ажлын байрны сургалтад нийт 127 ажилтныг хамруулсан. Аюулгүй ажиллагааны нийт 28 зааварчилгаа, 25 эрсдэлийн үнэлгээг хийж баталгаажуулсан. Ээлж солилцох бүрд Safety share хийх хуваарь гарган, 532 ажилтан яриа хийж, давтагдсан тоогоор 8973 ажилтан хамрагдсан.
4.2	Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий ажлын байруудад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлтгэх.	Ажлын явц, хувь	-	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5 дэх хэсгийг мөрдөн ажиллана.	Нийт ажлын байрнаас хортой, хүнд нөхцөлийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын “Тэтгэврийн хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2004 оны 77 дугаар тушаалыг үндэслэн гаргасан. Компанийн нийт ажлын байрны нэршлийг уг тушаалтай тулгах судалгааг хийж 97 ажлын байр хэвийн бусаар ангилан хор саармагжуулах бүтээгдэхүүнийг олгож байна. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 1 ажлын байрт хийхээр төлөвлөн эрх бүхий 2 байгууллагаас үнийн саналыг аван

					III-IV улирал: Ажлын байруудад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдсэн байна.	харьцуулалт хийж, "Хэлт энд сэфти солушинс" ХХК-иар 2,6 сая төгрөгөөр нийт 12 цэгт цулцанд нэвтэрдэг тоос, агаарын сорьцонд 13 төрлийн хүнд металлын хэмжилт хийлгэсэн.	
Зорилт 5. Статистик мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлнэ.							
5.1	Төмөр тээврийн хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийн мэдээллийн нэгдсэн санг бий болгох.	-	Мэдээллийн нэгдсэн сан бий болгох ажлын хэрэгжилт, хувь	Анхан шатны бичиг баримтыг бүрдүүлэлт, боловсруулалт хийгдсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Тээврийн анхан шатны бичиг баримтын бүртгэл, боловсруулалт хийгдсэн байна. Жилийн эцсийн байдлаар: III улирал: Мэдээллийн нэгдсэн санг бий болгохтой холбоотой компанийн хэмжээнд журам шинэчлэн батлах, мөрдөж эхэлнэ. IV улирал: Төмөр замын тээврийн тоон болон чанарын үзүүлэлтүүдийг мэдээллийн нэгдсэн санд багцлан нэгтгэх ажил 100 хувь хийгдсэн байна.	Галт тэрэгний хөдөлгөөн, ачаа тээвэр, зүтгүүр, вагоны аж ахуйн үндсэн 4 чиглэлээр үйлдэгдэж хөтлөгдсөн анхан шатны бичиг баримтуудыг бүрэн бүртгэж, нягталж тээврийн үндсэн үзүүлэлтүүдээр, хатуу тайлангууд, төмөр замын тээврийн болон хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийг бүрэн гаргаж, тайлагнаж ажилласан. Бүртгэлийг өдөр бүр файлаар хийж, мэдээллийн санг бүрдүүлэн ажилласан. Хоногийн мэдээ 331; Сарын тайлан 11; Улирлын тайлан 3; Хагас жилийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж, тайлагнан ажилласан.	100%
5.2	Зам, тээврийн салбарын хэмжээнд нэвтрүүлж буй төмөр тээврийн мэдээллийн нэгдсэн сан, платформд нэгдэх, компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх.	-	Нэгдсэн сан, платформд компанийн үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн эсэх	Мэдээллийн нэгдсэн сан, ажиглах талаар 60 цагийн сургалт, 4044 өгөгдөл оруулсан байна.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Төмөр замын тээврийн мэдээллийн нэгдсэн сан, платформд нэгдэх, сургалт, боловсон хүчин бэлтгэх ажил хийгдэнэ. Жилийн эцсийн байдлаар: III улирал: Сургалт зохион байгуулсан байна. IV улирал: Мэдээ тайланг журмын дагуу гаргаж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.	Зам, тээврийн салбарын нэгдсэн платформын холбогдох сургалтуудад бүрэн хамрагдаж, төлөвлөгөөт 60 цагийн /12 удаагийн/ хичээлд систем хөгжүүлэгч ажилтнууд бүрэн хамрагдсан. ЗТХЯ, ГТХЗНТ болон "Интерактив" ХХК-ийн холбогдох мэргэжилтнүүдтэй байнгын харилцаатай байж, шаардлагатай хөгжүүлэлт болон сургалтуудыг өөрийн компани дээр болон ГТХЗНТ дээр нийт 12 удаа хийж, оролцож ажилласан. Нэгдсэн платформд хоногийн ажилтын мэдээний 37 өгөгдөл, гол замын координатын нийт 48 өгөгдөл орж, эцсийн метаверс бүтээгдэхүүн болох үйл ажиллагаа бүрэн хийгдсэн. Компани нь тээврийн программ хангамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байгаагаас хамаарч бодит цагийн байдлаар мэдээллийг энэхүү платформ руу татуулахгүй байгаа хэдий ч өгөгдөл нэг бүрийг хоног тутамд шивж оруулан, мэдээлэлээр бүрэн хангаж ажиллаж байна. Сар, улирлын ажилтын мэдээний өгөгдлүүдийг бүрэн оруулсан. Мөн Ачаа тээврийн мэдээ Т-9 маягтыг шинээр хөтлөн ажилласан.	100%
5.3	Тээврийн нэгдсэн цахим программ хангамжийн	600 сая.төгрөг	Нэгдсэн цахим программыг	Цахим программ боловсруулах	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Судалгаа хийгдсэн байна.	Компанийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн дэд бүтцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, түргэн	

	худалдан авалт, компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх.	компанийн үйл ажиллагаан д нэвтрүүлсэн эсэх	ажлын даалгавар батлагдсан.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Программ хангамжийн худалдан авалт хийгдэж, тээврийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.	шуурхай болгох, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх талаар ажлын даалгавар, цаашд авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг Гүйцэтгэх захирлын 2023 оны А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан. Программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/284 дүгээр тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын суурь бүтцүүд байнгын ашиглалтад орсонтой холбогдуулан төмөр замын байгууллагууд тээврийн бичиг баримт, мэдээллийг харилцан дамжуулах, төлбөр тооцооны болон ачаа тээврийн захиалгын программ хангамжийн асуудлыг нэгдсэн байдлаар шийдвэрлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд "МТЗ" ТӨХК, "ТТЗ" ХХК болон "МТГ" ХХК нар хамтран зардлыг тэнцүү хуваан төлөх нөхцөлтэйгөөр нэгдсэн байдлаар программ хангамжийг шинээр хийлгэх, хөгжүүлэх ажлын даалгаврыг Ажлын хэсгээр дамжуулан "УБТЗ" ХНН-т хүргүүлсэн. Компанийн зүгээс ажлын даалгаврыг шинэчлэн боловсруулж, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ажлын хэсэгт цахимаар хүргүүлж, хариу шийдвэр, дүгнэлтийг хүлээж байна.	50%
Зорилт 6. Байгаль хамгаалах ажлыг зохион байгуулна.						
6.1	Байгаль орчны 2023 оны менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилт	Төлөвлөгөө боловсруулах ажил хийгдсэн.	Хагас жилийн байдлаар: I улирал: Тавантолгой-Гашуунсухайт, ТНАЛТ төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна.	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн 2023 оны "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланг Байгаль орчны мэдээллийн сан /www.eis.mn/-д 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр байршуулж, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/2093 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв төслийн 2023 оны "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланг Байгаль орчны мэдээллийн сан /www.eis.mn/-д 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр байршуулж, Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/2092 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100%
6.2	Хэрэгжиж буй БОННУ хийлгэж, батлуулах ажлыг зохион байгуулах.	БОННУ хийлгэж, батлуулсан эсэх	Эхний хувилбар хийгдсэн.	Жилийн эцсийн байдлаар: III улирал: Төслүүдийн БОННУ-г батлуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	"Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын төсөл"-ийн БОННУ-г батлуулж, "Шилжүүлэн ачих терминалын төсөл"-ийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулж, "Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох төсөл"-ийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулахаар ажиллаж байна. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замуудыг холбох төмөр замын төслийн Байгаль орчны	100%

						нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г "МЕЙК грийн" ХХК-иар гүйцэтгүүлж, БОННУ-ний тайланг 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Шилжүүлэн ачих терминалын төслийн байгаль орчны төлөв байдлын тайланг "Баялаг эко" ХХК-иар гүйцэтгүүлсэн ба Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 12/5494 дугаартай албан бичгээр Шилжүүлэн ачих терминал төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргуулсан. Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг холбох төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), иж бүрэн зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч болох БНХАУ-ын "Төмөр замын зураг төслийн корпораци" ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх туслан гүйцэтгэгчээр "Эхопланет" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Тус төслийн хүрээнд Байгаль орчны төлөв байдлын тайланг "Эхо планет" ХХК-иар, Угсаатны зүйн төлөв хамгаалах, Археологи, Палеонтологийн хайгуул судалгааны тайланг Шинжлэх ухааны академийн Археологийн Хүрээлэнгээр тус тус гүйцэтгүүлж, ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулахаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамд албан хүсэлт хүргүүлсэн.	100%
6.3	"Тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд мод тарьж ургуулах ажлыг зохион байгуулах.	-	Тарьсан модны тоо	2022 онд 4000 ширхэг хармаг модыг тарьсан.	Хагас жилийн байдлаар: II улирал: 2000 ширхэг мод тарьж ургуулсан байна. Жилийн эцсийн байдлаар: III улирал: 2000 ширхэг мод тарьж, нийт 4000 мод тарьсан байна.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хавар, намрын тариалалтаар "Тавантолгой өртөө"-ний хашаанд 2.5 км зурвас газарт 4475 мод тарьсан. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны 2023 оны 05/2234 дугаартай албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт, Хөшгийн хөндийн хурдны зам дагуу 250 ширхэг суулгац тариалсан. Ургалтын хугацаанд нийт 51 удаагийн усалгаа хийж, 1400 кг органик бордоогоор бордсон.	100%
Зорилт 7. Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.							
7.1	"Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэлийн мэдээг гаргах.	-	Гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн эсэх	2022 оны тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргэгдсэн.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Дуусаагүй үндсэн үйлдвэрлэлийг өртөгжүүлэн хөрөнгө бүртгэх, санхүүгийн тайлан гаргах, төслийн хөрөнгө оруулалт захиалагчийн хяналтын гүйцэтгэлийн мэдээг гаргасан байна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны 01/ТТЗ-ЗБТ дугаартай хяналт, шалгалтын үр дүнг үндэслэн явц дундын төлбөр баталгаажуулалт хүлээгдэж байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, явц дундын төлбөрийн гүйцэтгэл, захиалагчийн хяналтын санхүүжилтийн мэдээг тухай бүр боловсруулан ажилласан. Тус төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, захиалагчийн хяналтын санхүүжилтийн мэдээг Засгийн газрын хуралдаан, Засгийн газрын онцгой бүрэн эрхт	90%

7.2	"Тавантолгой-Зүүнбаян" чиглэлийн холболтын замын төмөр замын гүйцэтгэлийн мэдээг гаргах.	-	Гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн эсэх	2022 оны тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргэгдсэн.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Санхүүгийн тайлан гаргах, төслийн хөрөнгө оруулалт захиалагчийн хяналтын гүйцэтгэлийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. Хагас жилийн байдлаар: I-II улирал: Дуусаагүй үйлдвэрлэлийг үндсэн хөрөнгөд өртөгжүүлэн бүртгэх, санхүүгийн тайлан гаргах, төслийн хөрөнгө оруулалт захиалагчийн хяналтын гүйцэтгэлийн мэдээг гаргасан байна. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Санхүүгийн тайлан гаргах, төслийн хөрөнгө оруулалт захиалагчийн хяналтын гүйцэтгэлийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	Төвлөөлөгчийн 6 сарын ажлын тайланд танилцуулсан. Мөн "Эрдэнэс Монгол" ХХК-ийн чиглэлийн дагуу төслийн явцын тайланг гарган өгч мэдээллээр ханган ажилласан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 15 дугаар тогтоолоор "2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг ханган 2023 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөвт тодотгол хийх тухай" батлагдаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны гүйцэтгэлийн тайлан, мэдээг сар бүр гарган гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.	90%
7.3	"Тавантолгой нүүрс ачих логикийн төв" төслийн ажлын гүйцэтгэлийн мэдээг гаргах.	-	Гүйцэтгэлийн тайлан, мэдээг холбогдох байгууллагад хүргүүлсэн эсэх	2022 оны тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргэгдсэн.	Жилийн эцсийн байдлаар: III улирал: Явц дундын төлбөрийн хүсэлтийг баталгаажуулна. IV улирал: Санхүүгийн мэдээ тайланг гаргасан байна.	"Тавантолгой нүүрс ачих логикийн төв" төслийн ажлын гүйцэтгэл IV улирлын байдлаар 83.84% хувьтай, ИРС 6-г хянан баталгаажих, 254,316,097.86 мян.төгрөгийн санхүүжилт авсан байна. Төслийн ажил 2023 оны IV улирал дуусах төлөвлөгөөтэй байсан боловч хугацаа сунгагдаж 2024 оны I улирал дуусахаар төлөвлөгдөж, зарим зардалд өөрчлөлт орсонтой холбогдуулан, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 15 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийгдэж батлагдсан. Санхүүгийн мэдээ тайланг гарган ажиллаж байна.	90%

7.4	Тээврийн ажиллагааны санхүү, эдийн засаг, санхүүжилтийн үйл ажиллагааг тээвэр, суурь бүтцийн тарифт тулгуурласан эдийн засгийн тооцоо, гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх.	-	Эдийн засаг төлөвлөлтийн бодлогын баримт бичгийг батлуулж, програм хангамжийг нэвтрүүлсэн эсэх	Бэлтгэл ажлыг хангасан.	Хагас жилийн байдлаар: I улирал: Холбогдох шийдвэрүүдийг гаргасан байна. II улирал: Эдийн засаг төлөвлөлтийн бодлогын баримт бичгийг батлуулна. Жилийн эцсийн байдлаар: III улирал: Программ хангамжийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. IV улирал: Тээврийн үйл ажиллагааны санхүүжилтийн үйл ажиллагааг тээвэр, суурь бүтцийн тарифт тулгуурласан эдийн засгийн тооцоо, гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлсэн байна.	Төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой эдийн засгийн норм, тарифт нийцүүлэн холбогдох журмын судалгааг хийж, нийт 6 журмын төсөл танилцуулагдаж, хянагдсанаас 2 журам батлагдаж, мөрдөн ажиллаж байна.	70%
7.5	Компанийн батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэлээр зардлын санхүүжилтийг олгож хяналт тавьж, нэгдсэн санхүүгийн тайлан гаргаж ажиллах.	-	Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тайланг хүргүүлсэн эсэх	2022 оны тайлан мэдээг гаргасан.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэлээр зардлын санхүүжилтийг олгож хяналт тавьж ажиллана. Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Нэгдсэн санхүүгийн тайлан гаргаж, танилцуулж ажилласан байна.	Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн хүрээнд Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх удирдлагаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Тайлант хугацаанд төлөвлөгөөний биелэлт 91 хувийн гүйцэтгэлтэй гарсан ба тайланг холбогдох баримт, материалыг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1591 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.	100%
7.6	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 435, 459 дүгээр тогтоолын	-	Ажлын гүйцэтгэл	Нэгжүүдээс хэрэгжүүлэх ажлын санал авч,	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн Аудитын тайлбарын ажил дуусах, "Төрийн	Үндэсний Аудитын газраас хийсэн "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн Аудитын тайлбарын ажил дуусах, "Төрийн танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%

	хэрэгжилтийг хангах			төлөвлөгөө батлуулсан.	бүтээн төсөлд хөндлөнгийн аудит хийлгэж, дүнг холбогдох дээд шатны байгууллагад танилцуулсан байна.	аудитын тухай хууль-ийн 18 дугаар зүйлийн 18-ын 1 дэх хэсэгт заасны дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дагуу дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдийг нэг бүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж, 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдөр төв оффисын хурлын танхимд төслийн гүйцэтгэгч "Бодь интернэшнл" ХХК-ийн төлөөллийг байлцуулан уулзалт зохион байгуулж Аудитын ажлын хэсгийнхэнд танилцуулж хамтран ажилласан. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг холбогдох баримт, материалын хамт Үндэсний аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 1/1591 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хэрэгжүүлсэн Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, түүний зарцуулалт, бүртгэл, явц дундын төлбөрийн баталгаажуулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, компанийн үйл ажиллагаа, санхүүгийн бүртгэлд Олон улсын хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах хөндлөнгийн аудит хийлгэх үйлчилгээ үзүүлэх 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн АГТ-2023/33 дугаартай гэрээг "Грант тронтон аудит" ХХК-тай байгуулж, 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл тайлан зөвлөмжийг эцэслэн ирүүлэхээр ажиллаж байна.
Зорилт 8. Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.						
8.1	Хууль тогтоомж, Засгийн газар, төрийн бусад эрх бүхий байгууллагын шийдвэр, удирдамж, чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжилтийг хангуулах.	Хэрэгжилт йн хувь	2022 онд Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулж, дээд шатны байгууллагад танилцуулсан байна.		
						100%

						хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн нууцад хамааруулсан баримт бичиг, гэрээ болон тэдгээрийн хавсралтуудыг судалж, "Төрийн болон албаны нууцын тухай хууль", "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын дагуу "Маш нууц" зэрэглэлээс "Ил" болгох ажлыг Тагнуулын ерөнхий газраас санал, дүгнэлт авч, төслүүдийн маш нууц, нууц зэрэглэлтэй 40 гэрээг ил болгон олон нийтэд мэдээллэж, компанийн вэб сайтэд байршуулсан. Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 136 дугаар тогтоолоор "1955 оны "Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнансан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоол, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тус тус ханган ажиллаа. Компанийн "Хөдөлмөрийн дотоод журам", "Ес зүйн дүрэм"-ийн шинэчлэл энэ оны 03 дугаар сарын 27-ны өдрийн Гүйцэтгэх захирлын энэ оны А/28 дугаар тушаалаар баталсан. Хууль тогтоомж, Засгийн газар, төрийн бусад эрх бүхий дээд байгууллагын шийдвэр, удирдамж, чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжилтийг ЗТХЯ-нд 10 удаа хүргүүлсэн.	100%
8.2	Төлөөлөн удирдах зөвлөл Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаалыг хэрэгжүүлж, холбогдох эрх бүхий байгууллагад тайлагнах, мэдээллээр хангах.	-	Хэрэгжилтийн хувь	Шийдвэрт нийцсэн эдийн засгийн тооцоо, бүртгэл хийсэн.	Жилийн эцсийн байдлаар: III-IV улирал: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, дээд шатны байгууллага буюу Хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангасан байна.	Тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн хурал нийт 3 удаа хуралдаж, 4 асуудал хэлэлцэн 4 тогтоол гаргасан. Төлөөлөн Удирдах Зөвлөл нийт 12 удаа хуралдан 15 тогтоол, шийдвэр гаргасан бөгөөд тогтоол, шийдвэрийн биелэлт 98 хувьтай буюу "Бүрэн хэрэгжсэн" гэсэн үнэлгээтэй байна. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд "Тавантолгой төмөр зам"-ийн Гүйцэтгэх захирлын 141 тушаал батлагдаж, хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас ажлын хэсэг байгуулагдан ажилласан "А" тушаалын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 84 хувийн хэрэгжилттэй гарсан.	100%
8.3	Компанийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах.	-	Хэрэгжилтийн хувь	2022 онд Олон нийтэд компанийн үйл ажиллагааг сурталчилж, үнэн бодитой мэдээллийг оруулан ажилласан.	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Төлөвлөгөөг батлуулж, үр дүнгийн талаар олон нийтэд тухай бүр мэдээлж ажиллана. Жилийн эцсийн байдлаар: II-III улирал: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн	Компанийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох зорилгоор албан ёсны вэб www.tz.mn сайтыг шинэчилж, "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль", "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангуулахаар ЗГОБЭТ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/31 дугаартай тушаалаар холбогдох газар, нэгжид хамааралтай мэдээллүүдийг тогтмол олон нийтэд мэдээлж ажиллахыг үүрэг болгосон. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, шилэн дансны цахим хуудаст мониторинг хийх ажлын хүрээнд Гүйцэтгэх	100%

					дахуу үр дүнг танилцуулж, дүгнүүлсэн байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 80-аас доошгүй хувьтай байна.	захирлын А/50 дугаар тушаалаар "Шилэн дансны цахим хуудас хөтлөх журам батлах тухай" журмыг баталж, сар бүрийн 06-ны дотор мэдээллийг оруулан, хэрэгжилтийг хангуулан ажилласан. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн 5 бүлэг 47 заалтын 98 мэдээллээс компанийн үйл ажиллагаанд хамааралтай 58 мэдээг байршуулсан. 2023 онд Олон нийтэд компанийн үйл ажиллагааг сурталчилж, 540 мэдээ мэдээллийг оруулан ажилласан.	
8.4	Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион удирдлага байгуулалтаар хангах.	-	Хэрэгжилтийн хувь	2022 онд Бодлогын бичиг баримт бичгүүдийг бүх ажилтнуудад таниулан ажилласан.	Хагас жилийн байдлаар: I улирал: Төлөвлөгөөг батлуулж, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, бизнесийн ёс зүйн дүрмийг боловсруулах, дотоод журамд шаардлагатай өөрчлөлтийг оруулна. II улирал: Карьер хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн үнэлгээ, цалин хөлсний системийг шинэчлэн боловсруулна. Жилийн эцсийн байдлаар: III улирал: Тээвэрлэлтийн шаардлага хангасан бүтэц, зохион байгуулалт оновчтой болно. IV улирал: Цалингийн систем төмөр замын бусад ААН-тэй өрсөлдөхүйц хэмжээнд нэмэгдэж, ажилтны сэтгэл ханамж дээшилнэ.	Компанийн 2023 оны бүтэц, орон тооны шинэчлэлийн төслийг боловсруулан энэ оны 03 дугаар сарын 27-ны өдрийн захирлын зөвлөлийн хуралд урьдчилсан байдлаар танилцуулж, дахин боловсруулах үүрэг өгсөн. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох үүргийн дагуу компанийн бүтцийн төслийг боловсруулан, ЗТХЯ-нд энэ оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 1/1383 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/28 тоот тушаалаар Компанийн "Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм", мөн оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/61 тоот тушаалаар Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Ажилтнуудын хөгжлийг дэмжих, карьер хөгжлийн төлөвлөлтөө хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор "Карьер хөгжлийн төлөвлөгөөг хэрхэн гаргах вэ?" сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж, 39 ажилтан хамрагдсан. 2023 оны 11 дүгээр сарын тайлангийн гүйцэтгэлээр батлагдсан орон тоо 883, одоо ажиллаж байгаа 675 байна. Тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой 2023 оны III улирлын байдлаар харьяа нэгжийн захиалгын дагуу нийт 46 ажиллах хүчнийг шинээр ажилд авсан байна. Цалингийн ангилал, албан тушаалын зэрэглэлийг 2022 оны А/09 дүгээр тушаалаар баталсан цалингийн шатлалыг одоо мөрдөж байгаа бөгөөд Гүйцэтгэх захирлын 2023 оны А/121 дүгээр тушаалаар ажилтнуудын хөдөлмөрийн норм цалин хөлсний хэмжээг хөдөлмөр зарцуулалт тээврийн тарифтай нийцүүлж тогтоох ажлын хэсгийг байгуулан ажиллаж дүнг компанийн ТУЗ-д танилцуулахаар бэлтгэсэн. Ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Гүйцэтгэх захирлын 2023 оны А/65 дугаартай "Удаан жилийн нэмэгдэл олгох журам" батлагдаж, 09 дүгээр сард нийт 403 ажилтанд удаан жилийн нэмэгдэл олгосон.	30%
8.5	Төмөр мэргэжлийн ажилтнуудыг давтан сургах, үр чадварыг	-	Төлөвлөгөөний хэрэгжилт	"Хүний нөөцийн стратегийн 2021-2030	Хагас жилийн байдлаар: I-II улирал: Хүний нөөц, сургалтын төлөвлөгөөний төслийг боловсруулан	Компанийн 2023 оны хүний нөөц, сургалтын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гадаад-6, дотоод-46 сургалтыг тусган баталж, давхардсан тоогоор гадаад сургалтад 39, дотоод сургалтад 781 ажилтнууд хамрагдсан. Үүнд:	

	Дээшлүүлж, чадавхжуулах.			төлөвлөгөө* Бодлогын баримт бичиг	батлуулж, төлөвлөгөөний дагуу зохих сургалтууд хийгдсэн байна.	Чадавхжуулах 10 сургалтад 86 ажилтан; -Мэргэшүүлэх 15 сургалтад 265 ажилтан; -Хөгжүүлэх 9 сургалтад 323 ажилтан; -Циглүүлэх 16 сургалтад 107 ажилтан; -Гадаад сургалтад 39 ажилтнууд тус тус хамрагдсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/335 тушаалаар байгуулагдсан "Төмөр замын салбарын сургалт, хүний нөөцийн талаар баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах" ажлын хэсэгт Хүний нөөц, сургалтын хэлтсийн төлөөлөл орж ажиллан, компанийн зүгээс шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажилласан. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын А/154 тоот тушаалын 15 дугаар хавсралт "Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, шалгалт авах журам"-ын өөрчлөлтөд оруулах саналыг хүргүүлэн ажилласан.	100%
Зорилт 9. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.							
9.1	Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа нийт бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх.	-	Ажлын гүйцэтгэл, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны хэрэгжилт 83 хувь.	Хагас, бүтэн жилээр: I-IV улирал: Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлд дүгнэлт, зөвлөмж өгч, зөвлөмжийн бүрэн хэрэгжилтийг хангуулна.	Компанийн хэмжээнд мөрдөгдөж байгаа "Стратеги төлөвлөгөө-2050", "Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050", "Хүний нөөцийн стратеги 2021-2030" бодлогын бичиг баримтуудад хяналт, шинжилгээ, үнэлгээг хагас жил болон III улирлын байдлаар хийж, явцын үнэлгээний дүнг удирдлагад танилцуулсан. Жилийн эцсийн байдлаар үнэлгээг хийж, ЗТХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна. Жилийн эцсийн байдлаарх үнэлгээний дүнгээр: - "Стратеги төлөвлөгөө-2050" нийт 9 зорилтын хүрээнд 43 арга хэмжээний хэрэгжилт 88,44%-тай бөгөөд "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэй байна. - "Төмөр замын тээврийн хөгжлийн хөтөлбөр-2050" нь нийт 4 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ хэрэгжиж байгаагаас хэрэгжилт 83,1%-тай бөгөөд "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэй байна. - "Хүний нөөцийн стратеги 2021-2030" бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц 83,87%-тай бөгөөд "Тодорхой үр дүнд хүрсэн" гэсэн үнэлгээтэй байна.	100%

9.2	Компанийн хэлтсийн газар, үйл ажиллагаанд хяналт тавих.	-	Ажлын гүйцэтгэл, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх	Компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 91 хувь.	Хагас, бүтэн жилээр: Газар хэлтсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна.	-Үндэсний аудитын газрын "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн" сэдэвт гүйцэтгэл, нийцлийн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж, холбогдох газар хэлтсүүдэд хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. -Гүйцэтгэх захирлын "А" тушаалаар батлагдсан ажлын хэсгүүдэд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар үнэлгээ хийж, хяналт тавин ажиллаж байна. Газар, хэлтсүүдийн IV улирлын төлөвлөгөөг хянаж, баталсан. -Тавантолгой төмөр зам" ХХК-ийн төсөл хөгжлийн газрын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх удирдамжуудын хүрээнд хяналт, шалгалтын ажил хийгдэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагад танилцуулсан. Компанийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийхээр мэдээлэл цуглуулах шатандаа явж байна. -Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж, шилэн дансны цахим хуудаст мониторинг хийх ажлын хүрээнд Гүйцэтгэх захирлын А/50 дугаар тушаалаар "Шилэн дансны цахим хуудас хөтлөх журам батлах тухай" журмыг баталж, сар бүрийн 06-ны дотор мэдээллийг оруулан, хэрэгжилтийг хангуулан ажилласан.	100%
9.3	Төлөвлөгөөт хугацааны санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа хянан баталгаажуулах, дотоод аудитыг хэрэгжүүлэх.	-	Ажлын гүйцэтгэл, зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан эсэх	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 435, 459 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд шалгалт явагдаж байна.	Хагас, бүтэн жилээр: IV улирал: Тайлант хугацаанд санхүү бүртгэл, төсвийн гүйцэтгэлд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлсэн байна. Зөвлөмжийн хангагдсан хэрэгжилт байна.	-ЗГХЭГ-ын даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" энэ оны 94 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан төмөр замын төсөл" болон "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан, дотооддоо мөрдлөг болгон ажиллаж байна. Энэ хүрээнд 18,726,188.3 мян.төгрөгийн дүн бүхий 9 албан шаардлагаас 17,837,710.5 мян.төгрөгийн 7 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 888,477.8 мян.төгрөгийн 2 албан шаардлагыг биелүүлж ажил 90 хувьтай явагдаж байна. -Гүйцэтгэх захирлын шуурхай хуралдааны үүрэг, даалгаврын биелэлтэд 2023 оны 09 дүгээр сарын 29-ний байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулж батлуулсан. -Компанийн гадаад болон дотоод албан томилолтын зорилго, хэрэгжилт, үр дүнд хяналт шалгалт хийж, үнэлгээ, дүгнэлт гаргасан. Жилийн эцсийн байдлаар хяналт шалгалт хийхээр мэдээлэл цуглуулах шатандаа явж байна.	100%

9.4	Компанийн хэмжээнд хэрэгжүүлж төслүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх.	-	Ажлын гүйцэтгэл	Улирал бүр санхүүгийн тайлан гаргаж холбогдох байгууллагад хугацаанд нь хүргэсэн.	Хагас, бүтэн жилээр: III улирал: Төслийн үйл ажиллагаа батлагдсан төсөв, графикийн дагуу явагдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана. Төслүүдийн хэрэгжилтэд хийгдэх хяналт шинжилгээний ажил III улирал буюу 9 дүгээр сард хийгдэхээр Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу хийгдэж удирдлагад танилцагдсан. 2023 оны 12 дугаар сарын байдлаар төслүүдийн явц: 1.Тавантолгой-гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн явц -87,6% 2.Шилжүүлэн ачих терминал-98% 3.Тавантолгой-гашуунсухайт,Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг холбох төмөр замын төсөл-95.38% 4."Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв" төсөл-82% 5. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан холболтын төмөр зам төсөл-5%.	100%
Дундаж үнэлгээ						90.2

Төлөвлөгөөг хянасан:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Төсвийн ерөнхийлөн захирагч

/С.БЯМБАЦОГТ/

2023 оны 12 сарын өдөр

Төлөвлөгөөг тайлагнасан:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Төсвийн шууд захирагч

/Н.БУДБАЯР/

2023 оны 12 сарын 08-ны өдөр

